



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/48/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Болдбаатар
Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	1
1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4 Аудитын илрүүлэлт	15
4.1 Төлбөрийн акт	15
4.2 Албан шаардлага	15
4.3 Зөвлөмж	16
1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАРАЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 49
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ЭРДЭНЭЦАГААН
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА У.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>79,114,652.00</u>	<u>85,447,298.24</u>
33	АВЛАГА	31,220,425.00	26,300,803.24
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	31,220,425.00	26,300,803.24
35	БАРАА МАТЕРИАЛ	47,894,227.00	59,146,495.00
354	Хангамжийн материал	32,009,227.00	43,261,495.00
35410	Бичиг хэргийн материал	525,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	27,436,159.00	43,261,495.00
35440	Түлш, шатах тослох материал	4,048,068.00	00.00
35600	Мал амьтад	15,885,000.00	15,885,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,242,670,699.92</u>	<u>1,203,216,820.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,242,670,699.92	1,203,216,820.28
392	Биет хөрөнгө	1,233,182,699.92	1,193,728,820.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	855,326,399.47	855,326,399.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-216,001,597.16	-262,223,128.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	334,379,600.00	334,379,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-150,255,319.56	-195,623,266.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,208,460.00	283,424,720.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-126,155,094.21	-149,086,089.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,935,400.00	54,935,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,841,520.33	-27,255,149.94
39209	Зам, гүүрийн байгууламж	39,467,777.58	39,467,777.58
39210	Хуримтлагдсан элэгдэл	-3,946,777.80	-7,893,555.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	320,522,814.00	320,522,814.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-32,457,442.07	-52,246,700.63
393	Биет бус хөрөнгө	9,488,000.00	9,488,000.00
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,488,000.00	9,488,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,321,785,351.92</u>	<u>1,288,664,118.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>498,924.00</u>	<u>1,767,424.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	498,924.00	1,767,424.00
413	Өглөг	498,924.00	1,767,424.00
4136	Бусад өглөг	498,924.00	1,767,424.00
41361	Байгууллагад төлөх өглөг	427,500.00	1,687,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	71,424.00	79,924.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,321,286,427.92</u>	<u>1,286,896,694.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,321,286,427.92	1,286,896,694.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	244,255,121.82	244,255,121.82
51101	Өмч: - төрийн	244,255,121.82	244,255,121.82
512	Хуримтлагдсан үр дүн	671,572,021.52	637,182,288.12
51210	Өмнөх үеийн үр дүн	671,572,021.52	671,572,021.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-34,389,733.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	405,459,284.58	405,459,284.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,321,785,351.92</u>	<u>1,288,664,118.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,227,193,539.00	836,457,670.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	431,661,837.00	107,514,260.00
120	Нийтлэг татварын бус орлого	431,661,837.00	107,514,260.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	431,661,837.00	107,514,260.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	5,638,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,461,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	423,200,837.00	101,876,260.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	795,531,702.00	728,943,410.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,971,802.00	53,517,110.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,494,668.00	3,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,200,000.00	29,412,260.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,896,134.00	6,352,045.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,381,000.00	14,752,805.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	685,559,900.00	675,426,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	685,559,900.00	675,426,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	895,109,252.46	871,591,416.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	895,109,252.46	871,591,416.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	748,533,705.90	798,145,360.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283,495,236.00	292,583,051.43
210101	Үндсэн цалин	283,495,236.00	282,512,793.43
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	10,070,258.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,818,797.44	38,625,294.60
210201	Тэтгэврийн даатгал	25,037,133.67	27,126,406.05
210202	Тэтгэмжийн даатгал	2,851,171.23	3,003,639.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,233,816.92	2,381,875.17
210204	Ажилгүйдлийн даатгал	517,916.46	560,097.72
210205	Эрүүл мэндийн даатгал	5,178,759.16	5,553,275.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,865,519.00	24,636,380.90
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	4,199,999.44
210302	Түлш, халаалт	20,466,019.00	20,039,831.46
210303	Цэвэр, бохир ус	399,500.00	396,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,685,689.00	50,313,422.00
210401	Бичиг хэрэг	6,330,835.00	5,486,450.00
210402	Тээвэр, шатахуун	30,544,074.00	31,624,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,150,000.00	4,800,000.00
210404	Ном, хэвлэл	1,555,800.00	816,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	415,400.00	496,400.00
210408	Бараа материал акталсны зардал	5,689,580.00	7,089,672.00
2105	Нормативт зардал	500,000.00	900,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,838,820.00	10,420,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,450,300.00
210602	Тавилга	591,000.00	00.00
210604	Урсгал засвар	17,247,820.00	5,970,250.00

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	5,267,700.00	4,968,000.00
210702	Дотоод албан томилолт	5,267,700.00	4,968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,676,677.00	76,479,180.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,378,997.00	75,476,830.00
210803	Даатгалын үйлчилгээ	313,050.00	342,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	391,000.00	411,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	00.00
210807	Газрын төлбөр	49,630.00	160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	306,385,267.46	299,219,481.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	185,434,099.00	150,305,679.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,635,400.00	4,499,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	118,315,768.46	144,414,151.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,575,546.56	73,446,055.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,656,700.00	43,289,298.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,913,400.00	6,913,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,267,600.00	34,176,198.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,475,700.00	2,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	124,918,846.56	30,156,757.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,918,846.56	30,156,757.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>332,084,286.54</u>	<u>-35,133,745.55</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	62,747,713.10	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	62,747,713.10	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-62,747,713.10	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>269,336,573.44</u>	<u>-35,133,745.55</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,255,121.82	463,568,492.66	93,633,049.56	00.00	801,456,664.04
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,255,121.82	463,568,492.66	93,633,049.56	00.00	801,456,664.04
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	250,493,190.44	00.00	250,493,190.44
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,255,121.82	405,459,284.58	671,572,021.52	00.00	1,321,286,427.92
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,255,121.82	405,459,284.58	671,572,021.52	00.00	1,321,286,427.92
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,255,121.82	405,459,284.58	671,572,021.52	00.00	1,321,286,427.92
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-35,133,745.55	00.00	-35,133,745.55
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,255,121.82	405,459,284.58	636,438,275.97	00.00	1,286,152,682.37

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	831,411,777.00	751,617,835.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,461,000.00	5,638,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,461,000.00	5,638,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,461,000.00	5,638,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	5,638,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,461,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	822,950,777.00	745,979,835.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	137,390,877.00	70,553,535.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,494,668.00	3,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,619,075.00	46,448,685.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,896,134.00	6,352,045.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,381,000.00	14,752,805.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	685,559,900.00	675,426,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	685,559,900.00	675,426,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	812,225,777.00	747,777,835.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	812,225,777.00	747,777,835.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	648,613,805.44	648,030,976.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283,495,236.00	292,583,051.43
210101	Үндсэн цалин	283,495,236.00	282,512,793.43
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	10,070,258.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,818,797.44	38,625,294.60
210201	Тэтгэврийн даатгал	25,037,133.67	27,126,406.05
210202	Тэтгэмжийн даатгал	2,851,171.23	3,003,639.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,233,816.92	2,381,875.17
210204	Ажилгүйдлийн даатгал	517,916.46	560,097.72
210205	Эрүүл мэндийн даатгал	5,178,759.16	5,553,275.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,865,519.00	24,636,380.90
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	4,199,999.44
210302	Түлш, халаалт	20,466,019.00	20,039,831.46
210303	Цэвэр, бохир ус	399,500.00	396,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,353,777.00	43,223,750.00
210401	Бичиг хэрэг	6,855,835.00	5,486,450.00
210402	Тээвэр, шатахуун	34,292,142.00	31,624,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,150,000.00	4,800,000.00
210404	Ном, хэвлэл	1,555,800.00	816,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	496,400.00
2105	Нормативт зардал	500,000.00	900,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,613,600.00	12,838,540.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,496,800.00
210602	Тавилга	1,245,900.00	00.00

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	26,367,700.00	8,341,740.00
2107	Томилолт, зочны зардал	5,267,700.00	4,968,000.00
210702	Дотоод албан томилолт	5,267,700.00	4,968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,676,677.00	85,824,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,378,997.00	84,822,170.00
210803	Даатгалын үйлчилгээ	313,050.00	342,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	391,000.00	411,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	00.00
210807	Газрын төлбөр	49,630.00	160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	198,022,499.00	144,431,439.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	195,197,099.00	139,931,789.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,825,400.00	4,499,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	163,611,971.56	99,746,858.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,656,700.00	43,289,298.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,913,400.00	6,913,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,267,600.00	34,176,198.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,475,700.00	2,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	141,955,271.56	56,457,560.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	141,955,271.56	56,457,560.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,186,000.00</u>	<u>3,840,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>19,186,000.00</u>	<u>3,840,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>19,186,000.00</u>	<u>3,840,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>19,186,000.00</u>	<u>3,840,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,186,000.00	3,840,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-19,186,000.00</u>	<u>-3,840,000.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	680,786,300.00	650,907,542.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	680,786,300.00	650,907,542.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	636,330,600.00	607,618,244.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,366,600.00	292,583,051.43
210101	Үндсэн цалин	292,006,600.00	282,512,793.43
210105	Гэрээт ажлын хөлс	11,360,000.00	10,070,258.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,036,300.00	38,625,294.60
210201	Тэтгэврийн даатгал	28,040,500.00	27,126,406.05
210202	Тэтгэмжийн даатгал	3,071,900.00	3,003,639.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,436,300.00	2,381,875.17
210204	Ажилгүйдлийн даатгал	594,400.00	560,097.72
210205	Эрүүл мэндийн даатгал	5,893,200.00	5,553,275.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,934,900.00	24,636,380.90
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	4,199,999.44
210302	Түлш, халаалт	20,334,900.00	20,039,831.46

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	400,000.00	396,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,494,200.00	43,223,750.00
210401	Бичиг хэрэг	6,600,000.00	5,486,450.00
210402	Тээвэр, шатахуун	31,634,200.00	31,624,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,800,000.00	4,800,000.00
210404	Ном, хэвлэл	960,000.00	816,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	496,400.00
2105	Нормативт зардал	900,000.00	900,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900,000.00	900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,866,800.00	12,838,540.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,496,800.00
210604	Урсгал засвар	8,366,800.00	8,341,740.00
2107	Томилолт, зочны зардал	6,464,100.00	4,968,000.00
210702	Дотоод албан томилолт	6,464,100.00	4,968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,571,600.00	79,190,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,500,000.00	78,188,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	342,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	411,600.00	411,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	00.00
210807	Газрын төлбөр	160,000.00	160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,696,100.00	110,652,877.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,196,100.00	106,153,227.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,499,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,455,700.00	43,289,298.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,455,700.00	43,289,298.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,913,400.00	6,913,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,342,300.00	34,176,198.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.00	2,200,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	680,786,300.00	608,152,584.44
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	680,786,300.00	602,514,584.44
132001	Орон нутгийн төсвөөс	680,786,300.00	602,514,584.44
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	5,638,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,638,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	32.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	26.00	26.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32.00	32.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	08.00	08.00
650010	Гэрээт ажилтан	03.00	03.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	11.00	11.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,252,732.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44,252,732.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,252,732.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,634,170.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,634,170.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37618562.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,618,562.26
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70553535.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,553,535.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,448,685.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,352,045.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,752,805.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, шилэн данс, авлагатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ нь “Төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах иргэдэд ээлтэй төрийн бодлогыг хэрэгжүүлэх” гэсэн зорилгыг дэвшүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 848.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэв. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 871.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.1 сая төгрөгөөс 70 хувиар буюу 9.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **33.1** сая төгрөг буюу 2.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	31.2	26.3	-4.9
Бараа материал	47.9	59.2	11.3
Үндсэн хөрөнгө	1,242.7	1,203.2	-39.5
Нийт хөрөнгө	1,321.8	1,288.7	-33.1
Өр төлбөр	0.5	1.8	1.3
Засгийн газрын оруулсан капитал	244.2	244.2	-
Хуримтлагдсан үр дүн	671.6	637.2	-34.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	405.5	405.5	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,321.8	1,288.7	-33.1

Бараа материалын дансны үлдэгдэл 59.2 сая төгрөг болж 11.3 сая төгрөгөөр өссөн нь ковидтай холбоотой ариутгалын бараа материал худалдан авсан нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,203.2 сая төгрөг болж 39.5 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан 100.4 сая, урсгал төсвөөс худалдан авалтаар 3.8 сая, нийт 104.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 144.4 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,286.9 сая төгрөг болж, 34.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 390.7 сая төгрөгөөр буюу 31.8 Аудитын код: СБА-2022/48/НА-СТА-ТШЗ

хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан 321.3 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 56.4 сая, орон нутгийн санхүүжилт 10.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 23.5 сая төгрөг буюу 2.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бусад урсгал шилжүүлэг, бараа үйлчилгээний бусад зардал буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 685.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 685.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд 685.6 сая төгрөгийн төсөв баталснаас 685.6 сая орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 675.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаанд 650.9 сая төгрөгийг зарцуулж, 24.5 сая төгрөгийг буцааж төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 675.4 сая төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс дутуу санхүүжилт авсантай холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 3.0 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 29.4 сая, дээд шатны төсвийн захирагчаас 6.4 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 14.8 сая төгрөг нийт 53.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 6.6 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 37.6 сая нийт 44.2 сая төгрөгийг зарцуулж 9.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 зарлагын гүйлгээний 32.3 сая, урсгал санхүүжилтийн 18 гүйлгээний 378.9 сая төгрөгийг мэдээлээгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

3.9.2.1 Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”

3.9.2.2 Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль Аудитын код: СБА-2022/48/НА-СТА-ТШЗ

тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ нь тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4 Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 36.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 22.9 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

4.1.1 Ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг 0.3 сая төгрөгөөр төсвөөс илүү шилжүүлж, зардлаар илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн /Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 /үнэн зөв байх/, 20 дугаар зүйлийн 20.2.5 /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах/ дахь заалт болон ажил гүйлгээний анги, үйл явдал холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.2 Албан шаардлага

4.2.1 Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд нэр бүхий 11 ажилчны 1.1 сая төгрөгийн цалинг илүү тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 /үнэн зөв байх/, 14 дүгээр зүйлийн 14.4.6 /бүх зардал/ дахь заалт болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.2.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг баримтлалгүй албаны болон ажлын дүрэмт хувцас, урлагийн наадам, зөвлөгөөн, спортын уралдаан тэмцээн, телевизийн нэвтрүүлэг, бичиг хэрэг, цаас, хувилагчийн хор, зэрэгт 12.1 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.3 Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 зарлагын гүйлгээний 32.3 сая, урсгал санхүүжилтийн 18 гүйлгээний 378.9 сая төгрөгийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 65 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЗДТГ	6	36.3	1	22.9	1	0.3	3	1.3	1	-